



I-VI/2021

Тархаасан: 2021 оны 8 дугаар сарын 12



Барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний хагас жилд 23.2 хувиар буурлаа

Барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 1.5 их наяд төгрөг болж, 1.5 (96.8%) их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 48.9 (3.2%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.


ХҮСНЭГТ 1. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, гүйцэтгэгчийн төрлөөр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

	2018 I-VI	2019 I-VI	2020 I-VI	2021* I-VI	<u>2021* I-VI</u> <u>2020 I-VI</u>
	тэрбум төгрөг				хувь
Нийт	1 768.3	2 068.5	2 016.1	1 548.3	76.8
Дотоодын байгууллага	1 432.1	1 954.4	1 991.3	1 499.4	75.3
Төрийн	12.8	56.8	174.0	229.1	131.6
Хувийн	1 404.0	1 888.7	1 799.2	1 248.5	69.4
Гадаадтай хамтарсан	15.3	8.8	18.1	21.8	120.6
Гадаадын байгууллага	336.2	114.1	24.8	48.9	197.5

Барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 467.8 (23.2%) тэрбум төгрөгөөр буурахад гадаадын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 24.2 (97.5%) тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч дотоодын барилгын байгууллагынх 491.9 (24.7%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлөв.

Дотоодын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 1.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 550.7 (30.6%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 229.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 55.1 (31.6%) тэрбум төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагынх 21.8 тэрбум төгрөгт хүрч 3.7 (20.6%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 1. БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, төрлөөр, тэрбум төгрөг



Энэ оны эхний хагас жилийн байдлаар барилга угсралт, их засварын ажлын 33.9 хувийг орон сууцны барилга, 38.1 хувийг орон сууцны бус барилга, 25.6 хувийг инженерийн барилга, байгууламж, 2.4 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оны мөн үеэс их засварын ажлын эзлэх хувь 0.1 пунктээр, орон сууцны барилгынх 4.1 пунктээр тус тус өссөн бол инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 0.6 пунктээр, орон сууцны бус барилгынх 3.7 пунктээр буурсан байна.


ХҮСНЭГТ 2. ОРОН СУУЦНЫ БУС БАРИЛГА, ТӨРЛӨӨР, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

	2018 I-VI	2019 I-VI	2020 I-VI	2021* I-VI	<u>2021* I-VI</u> 2020 I-VI
	тэрбум төгрөг				хувь
Орон сууцны бус барилга	620.4	1002.6	842.2	590.3	70.1
Үйлдвэрийн	330.3	574.0	356.4	340.0	95.4
Худалдаа, үйлчилгээний	94.9	60.0	48.5	41.3	85.0
Эмнэлгийн	42.4	60.1	33.5	21.8	65.2
Сургууль, соёлын	77.1	199.1	234.6	113.0	48.1
Бусад	75.6	109.5	169.2	74.3	43.9

Орон сууцны бус барилгын гүйцэтгэл 2021 оны эхний хагас жилд урьдчилсан гүйцэтгэлээр 590.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 251.9 (29.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд худалдаа, үйлчилгээний барилгын ажил 7.3 (15.0%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилгынх 11.7 (34.8%) тэрбум төгрөгөөр, үйлдвэрийн барилгынх 16.5 (4.6%) тэрбум төгрөгөөр, орон сууцны бус бусад барилгынх 94.9 (56.1%) тэрбум төгрөгөөр, сургууль, соёлын барилгынх 121.6 (51.9%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

ЗУРАГ 2. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, тэрбум төгрөг

- Улаанбаатар хотод гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил
- Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил



Улаанбаатар хотод 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 618.4 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 41.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.2 пунктээр буурсан байна. Харин барилга угсралт, их засварын ажлын 58.8 хувийг аймаг, орон нутагт баригдаж буй барилга угсралт, их засварын ажил эзэлж байна.

Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр Өмнөговь аймагт 375.8 тэрбум төгрөг, Дорноговь аймагт 244.5 тэрбум төгрөг болж, энэ нь аймгуудын барилга угсралтын ажлын дүнд 70.4 хувийг эзэлж байна. Эдгээр аймгийн нутаг дэвсгэрт төмөр замын болон газрын тосны үйлдвэрийг дагасан барилга угсралтын ажил эрчимтэй явагдаж байна.

Ойлголт, тодорхойлолт

- Барилга угсралт, их засвар гэж барилга байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагааг ойлгоно.
- Орон сууцны барилга нь хамгийн багадаа түүний тал хэсгийг нь орон сууцны зориулалтаар ашигладаг байгууламж юм.
- Орон сууцны бус барилгад барилгын багахан хэсгийг (нийт талбайн 50%-иас бага хэсэг) орон сууцны зориулалтаар ашигладаг барилгыг оруулна.
- Инженерийн барилгын ажилд төмөр зам, зам, гүүр, хурдны зам, онгоцны буудлын талбай, ус хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга байгууламжийн бүх ажлыг оруулна.

Тайлбар: ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл



Эх үүсвэр: ҮСХ, Барилга байгууламж, объектын улирлын мэдээ (ББО-1)

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 11 дүгээр сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас: (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Д.Баасан
Утас: (976-510)-261502

